




- SOCIALPAY АППЛИКЕЙШНЫ ШИНЭЧЛЭГДСЭН ХУВИЛБАР

ГАРЫН АВЛАГА


Гар утасны дугаар ашиглан нэвтрэх зааварчилгаа:




01 SocialPay аппликэйшнг татаж, суулгана.




02 Нэвтрэх товч дээр дарна.




03 Гар утасны дугаараа оруулна.



04 Нэвтрэх товч дээр дарна.



05 Биометрик тохиргоог идэвхжүүлэх эсэхийг сонгоно.




06 SocialPay аппликэйшнд амжилттай нэвтэрснээр гүйлгээ цэс рүү шилжинэ.


Интернэт банкны эрх ашиглан нэвтрэх зааварчилгаа:



01 Нэвтрэх товч дээр дарна.



02 Интернэт банк товч дээр дарна.



03 Интернэт банкны нэвтрэх нэр, нууц үгийг оруулан үргэлжлүүлэх товч дээр дарна.




04 Биометрик тохиргоог идэвхжүүлэх эсэхийг сонгоно.




05 SocialPay аппликэйшнд амжилттай нэвтэрснээр гүйлгээ цэс рүү шилжинэ.

Нэрийн хуудас ашиглах зааварчилгаа:


SocialPay аппликэйшны зүүн дээд буланд байрлах өөрийн зурган дээр дарж орно.



01 Нэрийн хуудас товч дээр дарна.




02 Зүүн доод буланд байрлах товч дээр дарснаар Нэрийн хуудасны мэдээллийг засаж өөрчлөх боломжтой.




03 Нэрийн хуудасыг бусад руу илгээх бол баруун доод буланд байрлах товч дээр дарна.

Үлдэгдэл шалгах зааварчилгаа:




01 Үлдэгдэл товч дээр дарснаар Сошиал дансны үлдэгдэлийг шалгана.


Хамт олон үүсгэх зааварчилгаа:




01 Хамт олон товч дээр дарна.




02 Хамт олон үүсгэх товч дээр дарна.




03 Хамт олны нэр, тайлбар, тогтмол нэхэмжлэх дүн болон огноог оруулан Үргэлжлүүлэх товч дээр дарна.




04 Хамт олны данс нээх гэрээтэй танилцан Зөвшөөрөх дарна.



05 Хамт олны данс амжилттай үүснэ.




06 Шинээр үүссэн хамт олны мэдээлэл "Хамт олон" цэс дотор харагдана.




- 07 Хамт олонд байгаа **гишүүдийн жагсаалт** дээр дарж гишүүдийн мэдээллийг харах боломжтой.



- 08 **Гишүүн нэмэх** товч дээр дарснаар хамт олонд оруулах гишүүн рүү хүсэлт илгээх боломжтой.




- 09 Шинэ гишүүний мэдээллийг оруулан **Нэмэх** товч дээр дарж хамт олонд нэгдэх хүсэлтийг илгээнэ.



- 10 **Зарцуулах** товч дээр дарж хамт олны данснаас зарлага гаргана. Зөвхөн хамт олны админ дансныг захиран зарцуулах боломжтой.



- 11 Зарлага гаргах дүнг оруулж **зарцуулах** товч дээр дарна.




12

Зөвхөн хамт олны админ нэхэмжлэл үүсгэх боломжтой байна.




13

Хамт олноос нэхэмжлэх дүнг оруулж **Нэхэмжлэх** товч дээр дарна.




14

Хамт олны гишүүн нь дансны руу орлого хийх боломжтой.




15

Хамт олны данс руу хийх гүйлгээний дүнг оруулж **Цэнэглэх** товч дээр дарна.



16


Хамт олны админ нь дундын дансыг хаах буюу хамт олныг хаах боломжтой.



17


Хамт олны админ нь хамт олны мэдээллийг засах боломжтой.

Хүслийн хадгаламж үүсгэх зааварчилгаа:




01

Хүслийн хадгаламж товч дээр дарна.




02

Хүсэл нэмэх товч дээр дарна.




03


Хүслийн мэдээлэл болон мөнгөн дүнгийн хэмжээг оруулж Үргэлжлүүлэх дарна.



04 Хүслийн хадгаламжид тохирсон аль нэг зургийг сонгоно.




05 Таны оруулсан мөнгөн дүнд үндэслэн энгийн хугацаатай хадгаламж санал болгох бөгөөд та өөрийн хүссэн хугацаагаа сонгоно.




06 Хадгаламжийн нөхцөл болон гэрээтэй танилцаж, **Зөвшөөрөх** дарснаар хүслийн хадгаламж амжилттай үүснэ.


SocialPay аппликэйшнд найзаа урих зааварчилгаа:



01 **Найзаа урих** товч дээр дарна.




02 Утасны дугаарын жагсаалтаас сонгон **Invite** дарна.




03 Найзын урилга **амжилттай** илгээгдэнэ.


Данс солих тохиргоо хийх зааварчилгаа:



01 Тохиргоо цэсэд байрлах **Данс солих** дээр дарна.




02 Дансны жагсаалтаас аль нэгийг сонгоно.




03 Дансны мэдээлэлтэй танилцан **Зөвшөөрөх** дарснаар данс амжилттай солигдоно.

Картын тохиргоо хийх зааварчилгаа:




01 Тохиргоо цэсэд байрлах **Картын тохиргоо** дээр дарна.




02 Картын жагсаалтаас **сонгосноор** таны карт амжилттай солигдоно.

Утасны дугаар солих зааварчилгаа:



01


Тохиргоо цэсэд байрлах **Утасны дугаар солих** дээр дарна.



02

Шинээр холбох утасны дугаарыг оруулж **Үргэлжлүүлэх** дарснаар амжилттай солигдоно.


Touch ID тохиргоо хийх зааварчилгаа:




01

Тохиргоо цэсэд байрлах **Touch ID тохиргоо** идэвхжүүлнэ.


Сошиал пин солих зааварчилгаа:




01 Тохиргоо хэсэгт байрлах **Social Pin солих** дээр дарна.




02 Өөрийн ашиглаж буй **ПИН** кодыг оруулна.



03 **Шинэ ПИН** кодыг оруулна.




04 Бүртгэлтэй гар утасны дугаарт ирсэн нэг удаагийн баталгаажуулах кодыг оруулан **Үргэлжлүүлэх** дарна.




05 Social Pin **амжилттай** солигдоно.


Өнгө солих зааварчилгаа:



01 Тохиргоо цэсэд байрлах **Өнгө солих** дээр дарна.




02 Өөрийн хүссэн өнгийг сонгож **Сонгох** дарна.



03 SocialPay аппликэйшн өнгө амжилттай солигдоно.

Хэл солих зааварчилгаа:




01 Тохиргоо цэсэд байрлах **Change language** дээр дарснаар Англи болон Монгол хэлээр солигдоно.


SocialPay аппликэйшн ашиглан утасны дугаараар шилжүүлэг хийх зааварчилгаа:




01 Илгээх мөнгөн дүнг оруулж **Илгээх** товч дарна.



02 **SocialPay** үйлчилгээг сонгож, хүлээн авагчын гар утасны дугаарыг оруулах эсвэл утасны дугаарын жагсаалтаас сонгон **Нэхэмжлэх** товч лээр дарна.




03 Гүйлгээний утга оруулан **Илгээх** товч дээр дарна.




04 Гүйлгээ амжилттай илгээгдэнэ.

Бусад банкны данс руу шилжүүлэг хийх зааварчилгаа:




01

Илгээх мөнгөн дүнг оруулж **Илгээх** товч дарна.




02

Хүлээн авагч банкыг сонгож дансны дугаарыг оруулан **Илгээх** товч дээр дарна.



03


Гүйлгээний утгыг оруулан **Илгээх** товч дээр дарна.




04

Гүйлгээ амжилттай илгээгдэх ба гүйлгээ хийсэн дансыг **хадгалах** боломжтой.


Нэхэмжлэх илгээх зааварчилгаа:



01 Нэхэмжлэх мөнгөн дүнг оруулж **Нэхэмжлэх** товч дарна.




02 Нэхэмжлэх утасны дугаарыг оруулах эсвэл утасны дугаарын жагсаалтаас сонгон **Нэхэмжлэх** товч дээр дарна.




03 Гүйлгээний утгыг оруулан **Нэхэмжлэх** товч дээр дарснаар амжилттай нэхэмжлэх илгээгдэнэ.


Виртуал карт үүсгэх зааварчилгаа:




01 Хэтэвч цэсний баруун дээд буланд байрлах **Карт нэмэх** дүрс дээр дарна.




02 Виртуал картын хэсэгт байрлах **Үүсгэх** товч дээр дарна.



03 VISA, Master, UnionPay картын сүлжээнээс **сонгоно**.




Таны бүртгэлтэй гар утасны дугаарт нэг удаагийн баталгаажуулах код илгээгдэх ба кодыг оруулан [Үргэлжлүүлэх](#) товч дээр дарна.




Үйлчилгээний нөхцөлтэй танилцан [Үргэлжлүүлэх](#) товч дарснаар амжилттай виртуал карт үүснэ.


Бусад банкны картаа холбох зааварчилгаа:




01 Хэтэвч цэсний баруун дээд буланд байрлах [Карт нэмэх](#) дүрс дээр дарна.



02 Банкны карт хэсэгт байрлах [бусад банкны карт холбох](#) болно Голомт банкны картыг захиалах боломжтой.




03 Банкны картны дугаар болон хүчинтэй хугацаа, CVV кодыг оруулснаар [Үргэлжлүүлэх](#) товч дээрр дарна.



04

Таны холбож буй банкны картын мэдээллийг баталгаажуулахаар бүртгэлтэй имэйл хаягт **Dynamic password** илгээгдэх ба кодыг оруулаад **PAY** дарснаар карт амжилттай холбогдоно.

Картын жагсаалт харах зааварчилгаа:



01


Хэтэвч цэсний баруун дээд буланд байрлах **хэтэвчний дүрс дээр** дарна.



02


Таны ашиглаж буй картууд харагдана.

Лоялти цэс ашиглах зааварчилгаа:




01

Лоялти цэсний **Хөтөлбөр** дээр дарж урамшуулалт аяны талаар мэдээлэл авах боломжтой.




02

Мөн урамшуулалт аян, хөтөлбөрүүд рүү орсноор дэлгэрэнгүй мэдээлэл болон цуглуулсан оноог харах боломжтой.



03

Данс хэсгээс та өөрийн сугалааны мэдээллийг харах боломжтой.



04


Лоялти цэсний **Купон** дээр дарж таны авсан купоны мэдээлэл харагдана.

Нэмэлт үйлчилгээ цэсийг ашиглах зааварчилгаа:




01

Нэмэлт үйлчилгээ цэснээс SocialPay онцлох үйлчилгээнүүдийг авах боломжтой.



02

Мөн санал болгох үйлчилгээнүүдээс сонгон ашиглах боломжтой.




03

Жагсаалт хэсгээс даатгал, санхүүгийн үйлчилгээ, энтертаймэнттэй холбоотой үйлчилгээнүүдээс авах боломжтой.



04


Мөн хандив, хувьцаа арилжаа, эрүүл мэндийн үйлчилгээнүүдийг авах боломжтой.




05

Зорчигч тээвэр, онлайн дэлгүүр болон амралт зугаалгатай холбоотой үйлчилгээнүүдийг авах боломжтой.


Автомашины татвар болон торгууль төлөх зааварчилгаа:




01 Нэмэлт үйлчилгээ цэснээс **Машин** товч дарна.



02 **Машин холбох** + товч дээр дарна.



03 Машины улсын дугаарыг оруулан **Үргэлжлүүлэх** товч дээр дарна.



04 Машин амжилттай холбогдоно.




05 Машин хэсэгт холбосон **машины дугаар** дээр дарна.




06 Автомашины төлөх татвар болон торгуулийн дүн харагдах ба төлбөр төлөх банкны картыг холбох боломжтой.


Гар утасны нэгж, дата, төлбөр төлөх зааварчилгаа:




01 Нэмэлт үйлчилгээ цэснээс **Гар утас** товч дарна.




02 Гар утасны дугаарыг оруулан **Done** товч дээр дарна.



03 Төлбөр хэсэгт мөнгөн дүнг оруулж **Төлөх** товчыг дарснаар гар утасны төлбөр төлөх боломжтой.




04 **Data** хэсэгт дарснаар танд санал болгох багцаас сонгон дата авч цэнэглэх боломжтой.




05 Нэгж хэсэгт дарснаар өөрийн хүссэн дүнгээр утасны дугаарыг нэгжээр цэнэглэх боломжтой.


Хэрэглээний төлбөр төлөх зааварчилгаа:



01 Нэмэлт үйлчилгээ цэснээс **Байр дээр** товч дарна.



02 Хэрэглээний төлбөр + **нэмэх** товч дээр дарна. Тогтмол төлдөг хэрэглээний **төлбөрийг бүртгэх** боломжтой.



03 Дээрх хэрэглээний төлбөрүүдээс сонгон төлөх боломжтой.